

“ДАРХАН-ЭРДЭНЭТИЙН АВТО ЗАМААС АМАРБАЯСГАЛАНТЫН ХИЙД ЧИГЛЭЛИЙН 63 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ ТӨСӨЛ”-ИЙН КОНЦЕССЫН ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

2017 оны 03 дүгээр
сарын 30-ны өдөр

Улаанбаатар
хот

Энэхүү Гэрээ (цаашид “Нэмэлт гэрээ” гэх)-г Концессын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн “Концессоор хэрэгжүүлэх авто замын төслүүдийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 84 дүгээр тогтоол, Засгийн газрын хуралдааны 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 63 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн нэг талаас Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар /цаашид “Эрх бүхий этгээд” гэх/-ын дарга Б.Баярсайхан;

Нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан “Пик девелопмент” ХХК, түүнийг төлөөлж гүйцэтгэх захирал Б.Насанжаргал /цаашид “Концесс эзэмшигч” гэх/ нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

1.1. “Дархан-Эрдэнэтийн авто замаас Амарбаясгалантын хийд чиглэлийн 63 км авто зам төсөл”-ийг хэрэгжүүлэх концессын гэрээний нүүрний хэсгийн “Дархан-Эрдэнэтийн авто замаас Амарбаясгалантын хийд чиглэлийн 63 км авто зам төсөл” гэснийг “Дархан-Эрдэнэтийн авто замаас Сант сум, Орхон сум чиглэлийн 22.2 км хатуу хучилттай авто зам төсөл” гэж, гэрээний зорилго хэсгийн “Дархан-Эрдэнэтийн авто замаас Амарбаясгалантын хийд чиглэлийн 63 км авто зам” гэснийг “Дархан-Эрдэнэтийн авто замаас Сант сум, Орхон сум чиглэлийн 22.2 км хатуу хучилттай авто зам” гэж, 1.5 дах хэсгийн “1.3.1-1.3.3-т” гэснийг “1.3.1, 1.3.2-т” гэж, 1.10 дахь хэсгийн “75,600,000,000 (далан таван тэрбум зургаан зуун сая)” гэснийг “26,640,000,000 (хорин зургаан тэрбум зургаан зуун дөчин сая)” гэж, 1.12 дахь хэсгийн “1.3.1-1.3.3-т” гэснийг “1.3.1, 1.3.2-т” гэж, 1.13 дахь хэсгийг “Концесс эзэмшигч нь авто замыг хэсэгчлэн хүлээлгэн өгөх бөгөөд Улсын комисст хүлээлгэн өгснөөр баталгаажна” гэж, 1.14 дэх хэсгийн “Концессын зүйлийг концесс эзэмшигч нь ашиглалтад хүлээлгэн өгсөн өдрөөс хойш түүний баталгаат хугацаа 3 жил байна.” гэснийг “Концессын зүйлийг концесс эзэмшигч нь ашиглалтад хүлээлгэн өгсөн өдрөөс хойш түүнийг зүгшрүүлэх хугацаа 1 жил, баталгаат хугацаа 3 жил байна.” гэж өөрчлөн найруулав.

1.2. Гэрээний 1.16 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулав.

№	Төлбөрийн дүн /төгрөг/	Төлбөрийн дүн /үсгээр/	Төлбөр гүйцэтгэх /он/
1	9,057,600,000	Есөн тэрбум тавин долоон сая зургаан зуун мянга	2017
2	8,791,200,000	Найман тэрбум долоон зуун ерэн нэгэн сая хоёр зуун мянга	2018
3	8,791,200,000	Найман тэрбум долоон зуун ерэн нэгэн сая хоёр зуун мянга	2019

1.3. “Дархан-Эрдэнэтийн авто замаас Амарбаясгалантын хийд чиглэлийн 63 км авто зам төсөл”-ийг хэрэгжүүлэх концессын гэрээний 1.3.3, 1.4, 6.8 дахь хэсгийг тус тус хасахаар харилцан тохиролцов.

ХОЁР. БУСАД ЗОХИЦУУЛАЛТ

- 2.1. Энэхүү нэмэлт гэрээгээр нэмэлт өөрчлөлт оруулсан заалтуудаас бусад Концессын гэрээний зохицуулалт нь хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.
- 2.2. Энэхүү нэмэлт гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох бөгөөд Концессын гэрээний салшгүй хэсэг байна.
- 2.3. Нэмэлт гэрээ нь адил хүчинтэй хоёр хувь үйлдэгдсэн бөгөөд Концессын гэрээний хугацаанд хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙГ ТӨЛӨӨЛЖ:
Гарын үсэг:

Нэр: Б.Баярсайхан
Албан тушаал: Үндэсний хөгжлийн
газрын дарга
Тамга:



КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
Гарын үсэг:

Нэр: Б.Насанжаргал
Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Тамга:

